



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 01 сарын 31-ны
өдрийн 3846 дугаарт бүртгэв.

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот


Цэвэр, бохир усны үйлчилгээний
тариф, төлбөр тооцох аргачлал батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан аргачлалыг мөрдөж ажиллахыг Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, хэвлэл мэдээллээр сурталчилж, үр дүнг тооцож ажиллахыг Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮН



Э.ПҮРЭВЖАВ

Б.ЖИГЖИД

Ч.БАТТОГТОХ

С.ЧУДУУНХУЯГ

Р.НЯМЖАВ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны 01-р сарын 19-ны өдрийн тоот тогтоолын хавсралт

ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ, ТӨЛБӨР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү аргачлалыг Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.1, 10.2 дугаар зүйлийг тус тус үндэслэн боловсруулсан болно.
- 1.2 Энэхүү аргачлалын зорилго нь тухайн орон нутагт ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид "ТЗЭ" гэх)-ийн мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф тогтоох, төлбөрийг тооцоход оршино.
- 1.3 ТЗЭ нь үйл ажиллагааны сүүлийн 3 жилийн бодит зардлын гүйцэтгэл, ирэх оны төлөвлөгөөнд тулгуурлан энэхүү аргачлалын дагуу тарифаа тооцож, саналыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд (цаашид "Зохицуулах зөвлөл" гэх) ирүүлнэ.
- 1.4 Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тариф тогтоохдоо үйлчилгээний онцлог, шинж чанараас нь хамааруулан дараах бүтцийн аль нэгийг сонгоно. Үүнд:
 - 1 шатлалтай
 - 2 шатлалтай (суурь үнэтэй)
 - Шатлан өсөх (усны хэмжээ болон хаягдал бохир усны бохирдлын хэмжээ)
- 1.5 Үнэ тарифын тооцоонд техник эдийн засгийн биет болон мөнгөн үзүүлэлт, усны баланс, зардлын үндэслэлийг холбогдох тайлбар тооцоо, баталгаажуулах баримтын хамт хавсаргана.

Хоёр. Нэр томъёо

Энэхүү аргачлалд хэрэглэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1 **Бүрэн өөрийн өртөг (БӨӨ)** - Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт зардал /зээлийн хүүгийн зардлыг тооцоогүй/;
- 2.2 **Тариф (Т)** - Цэвэр ус олборлон түгээх эсвэл бохир ус татан зайлуулах нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр;
- 2.3 **Суурь үнэ (Сү) буюу суурь хураамж** – Үйлчилгээг байнгын бэлэн байдалд байлгахад шаардагдах тогтмол зардалд суурилсан тариф (цаашид энэхүү аргачлалд суурь үнэ гэж оруулав);
- 2.4 **Нийт зардал (НЗ)** - Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг, зээлийн хүүгийн зардлын нийлбэр;
- 2.5 **Тогтмол зардал (Тз)** – Хангагч байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээнээс үл хамааран гарах ажиллагсдын болон удирдлагын зэрэг тогтмол зардлын дүн,
- 2.6 **Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БОш)**- Тусгай зөвшөөрлийн хүрээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, хэрэглэгчдэд найдвартай, чанартай

ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлын хэмжээ;

- 2.7 **Үйлчилгээний биет хэмжээ ($Y_{б.х}$)**- Ус хангамжийн үйлчилгээний биет хэмжээ буюу хэрэглэгчдэд борлуулсан цэвэр ус, татан зайлуулсан хаягдал бохир усны хэмжээ, (цэвэр усны хэмжээ нь хэрэглэгчид хүргэж буй халуун, хүйтэн усны нийлбэрээр тодорхойлогдоно);
- 2.8 **Зардал тооцох усны хэмжээ ($X_{цү}, X_{бу}$)** – Үйлчилгээний биет хэмжээ буюу хэрэглэгчдэд борлуулсан цэвэр ус, татан зайлуулсан хаягдал бохир ус;
- 2.9 **Хэрэглэгчийн тоо (X)** – Хангагч байгууллагатай гэрээтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоо;
- 2.10 **Богино хугацаат өр төлбөр ($\Theta_{бх}$)** – Нэг жилийн дотор төлөгдөх өр төлбөр;
- 2.11 **Урт хугацаат өр төлбөр ($\Theta_{ух}$)** – Нэгээс дээш жилийн дараа төлөгдөх өр төлбөр;
- 2.12 **Зээлийн хүүгийн зардал ($Z_{бхх}$)** - Тайлант хугацаанд төлөгдөх богино хугацаат зээлийн хүүгийн зардал;
- 2.13 **Үндсэн хөрөнгө (YX)** – Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд урт хугацаагаар ашиглагдах хөрөнгө;
- 2.14 **Хөрөнгө оруулалтын өгөөж ($XO_ө$)** – Урт хугацаат зээлийн хүүгийн болон ажиллагсдын нийгмийн зардлыг тусгасан хөрөнгө оруулалтаас олох ашгийн хэмжээ;
- 2.15 **Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь ($XO_{өх}$)** – Урт хугацаат зээлийн хүү, өөрийн хөрөнгийн өгөөжийн хувийн жигнэсэн дундаж;
- 2.16 **Өгөөж тооцох үндсэн хөрөнгө ($X_{ө.т}$)** - Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд ашиглагдах үндсэн хөрөнгийн үлдэгдэл үнэ;
- 2.17 **Эргэлтийн хөрөнгө (ΘX)** – Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нэг жилийн хугацаанд ашиглагдах түлш, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал, авлага, мөнгөн хөрөнгийн дүн;
- 2.18 **Элэгдэл ($\Theta_э$)** – Тухайн жилд байгуулагдах үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын хэмжээ;
- 2.19 **Хуримтлагдсан элэгдэл ($\Theta_х$)** - Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаанд үүссэн элэгдэл хорогдлын хэмжээ;
- 2.20 **Зөөврийн усны алдагдал ($A_э$)** – Зөөврийн усны үйлчилгээний санхүүгийн алдагдлын хэмжээ;
- 2.21 **Өгөөж тооцоох хөрөнгө оруулалт ($XO_{ө.т}$)** - Өгөөж тооцох үндсэн хөрөнгө, өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн нийлбэр;
- 2.22 **Орлого болоогүй ус (ОБУ)** – Олборлон боловсруулсан боловч бичилт хийгдэж төлбөр ногдуулаагүй усны хэмжээ;
- 2.23 **Усны зөвшөөрөгдөх алдагдал ($YA_э$)** – усны зүй бус алдагдлаас бусад буюу гал, дотоод хэрэгцээ, технологи, засвар үйлчилгээ, осол аваарын үед алдсан усны нийт хэмжээ;
- 2.24 **Технологийн усны алдагдал ($YA_т$)** - Усыг цэвэршүүлэх явцад хаягдсан усны хэмжээ;

Гурав. ТЗЭ-ийн цэвэр, бохир усны үйлчилгээний тариф тогтооход баримтлах зарчим

- 3.1 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах.
- 3.2 Цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, зөөвөрлөн түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх.
- 3.3 Өртөг нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх.
- 3.4 ТЗЭ-ийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны тарифын орлого нь хэрэглэгчдэд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг тасралтгүй хүргэх, урсгал засвар үйлчилгээг өөрийн санхүүжилтээр гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх.
- 3.5 Усны үйлчилгээний санхүүгийн алдагдлыг нөхөх зорилгоор орон нутгаас олгох санхүүгийн эх үүсвэр нь батлагдсан татаасыг тарифын тооцоонд оруулж тооцох.
- 3.6 Тариф тооцох зардалд ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардалд бодогдох элэгдэл, хорогдлыг оруулахгүй байх,
- 3.7 Зохистой хэрэглээг урамшуулах, суурь үнэ тогтоох,
- 3.8 Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх зардлын бодит өөрчлөлтөөс хамааран тарифыг индексжүүлэх чиглэл баримтлах,
- 3.9 Цэвэр бохир усны үйлчилгээний тариф тооцох зардалд ТЗЭ-ийн үйл ажиллагаанд хамааралгүй бүх төрлийн шагнал урамшуулал, тэтгэмж, хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газар зэрэг үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй байх.
- 3.10 Усны зохистой хэрэглээг урамшуулах, усны бохирдлыг бууруулах, хүн амын зорилгоор хэрэглэгчийн ангиллаар ялгавартай тариф тогтоох.
- 3.11 Хүн амын эмзэг бүлгийг хамгаалах зорилгоор зөөврийн ус хангамжийн тарифыг байгууллагын дундаж тарифт тулгуурлан тогтоох.
- 3.12 Хэрэглэгчид болон ТЗЭ-дийн санхүүгийн үйл ажиллагааны тогвортой байдлыг хангах зорилгоор тарифын зохицуулалтыг санхүүгийн жилтэй уялдуулах.

Дөрөв. Тариф тооцоход ашиглах хэрэглэгчдэд нийлүүлэх цэвэр ус, хүлээн авах бохир усны хэмжээг тооцох

- 4.1 Үйлчилгээний биет хэмжээг тогтоохдоо сүүлийн жилүүдэд хэрэглэгчдэд түгээсэн усны бодит хэмжээ (татан зайлуулсан бохир ус) болон хэрэглэгчийн тооны өөрчлөлт, төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын системд шинээр холбогдох болон хасагдах хэрэглэгчид, тоолууржилт зэргийг тус тус харгалзан үзнэ.
- 4.2 Үйлчилгээний биет хэмжээг дараах томъёогоор тодорхойлно:

$$Y_{\text{бх}} = \sum Y_{\text{бх}_i}^T + \sum Y_{\text{бх}_i}^{T-\text{гүй}} + \Delta Y_{\text{бх}}^X \quad (1)$$

Үүнд: $Y_{\text{бх}}$ - үйлчилгээний биет хэмжээ төлөвлөгөөт оноор, мян.м³;

$Y_{\text{бх}_i}^T$ - i ангиллын хэрэглэгчийн тоолууртай ус хэрэглээ, суурь оноор, мян.м³;

$Y_{\text{бх}_i}^{T-\text{гүй}}$ - i ангиллын хэрэглэгчийн тоолууртай ус хэрэглээ, суурь оноор, мян.м³;

$\Delta Y_{\text{бх}}^X$ - ус хэрэглээний өөрчлөлтийн төлөвлөгөө, мян.м³;

Тайлбар: Дулаан үйлдвэрлэдэг ТЗЭ-д үйлчилгээний биет хэмжээнд дулааны зориулалтаар ашигласан усыг оруулж тооцно.

4.3 Хэрэглэгчийн өсөлт, бууралт, тоолууржилт болон бусад шалтгаанаар өөрчлөгдөх ус хэрэглээний төлөвлөгөөг дараах томъёогоор тооцно:

$$\Delta Y_{\text{бх}}^x = \Delta Y_{\text{УААНБ}} + \Delta X_{\text{Т.а}} \cdot t \cdot V_{\text{дх}} \cdot 10^{-3} + \Delta X_{\text{Т-гүй.а}} \cdot t \cdot N_{\text{ух}} \cdot 10^{-3} + \Delta Y_{\text{бус}} \quad (2)$$

Үүнд: $\Delta Y_{\text{бх}}^x$ – ус хэрэглээний өөрчлөлт, төлөвлөгөөгөөр, мян.м³;

$\Delta Y_{\text{УААНБ}}$ – үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын ус хэрэглээний өөрчлөлт төлөвлөгөөгөөр, гэрээнд орох өөрчлөлт /энэ ангиллын хэрэглэгчийн тооны өсөлт, бууралт, тэдгээртэй хийх ус ашиглалтын гэрээнд үндэслэн тооцоолно/ мян.м³;

$\Delta X_{\text{Т.а}}$ – тоолууртай ахуйн хэрэглэгчийн өсөлт бууралт, тоогоор;

t- шинэ хэрэглэгч холбогдсоноос хойш жилийн эцэс хүртэлх хугацаа, хоногоор;

$V_{\text{дх}}$ – 1 хэрэглэгчийн дундаж хэрэглээ, суурь оноор, л/хоног;

$N_{\text{ух}}$ – ус хэрэглээний норм, л/хоног;

$\Delta Y_{\text{бус}}$ – ус хэрэглээнд гарах төлөвлөсөн бусад өөрчлөлтүүд, мян.м³.

4.4 Ус дамжуулан түгээж байгаа тохиолдолд зардалд тооцох усны хэмжээг дараах томъёогоор тодорхойлно:

$$X_{\text{цү}} = Y_{\text{бх}} + УА_з + X_{\text{гү}} \quad (3)$$

Үүнд: $X_{\text{гү}}$ – галын усны хэрэглээ (ТЗЭ-ийн бүртгэсэн болон Онцгой байдлын газрын ус авдаг цэгүүдэд хийсэн судалгаа, тайланг үндэслэн тооцно), жилээр, мян.м³;

$УА_з$ - Усны зөвшөөрөгдөх алдагдал, жилээр, мян.м³.

4.5 Усны зөвшөөрөгдөх алдагдал нь дотоод хэрэглээ, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын үед алдсан усны хэмжээний нийлбэртэй тэнцүү байна. Дотоод хэрэглээний ус нь:

- Өөрийн унд ахуйн хэрэгцээнд зарцуулсан ус;
- Ус цэвэршүүлэх явцад гарсан технологийн хаягдал ус;
- Шугам сүлжээ, усан сангийн угаалга, ариутгалын ус;
- Насосны станцын өөрийн хэрэглээ;
- Бохир усны шугамын угаалга, цэвэрлэгээнд хэрэглэсэн усны хэмжээгээр тодорхойлогдоно.

Тав. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлох

5.1 ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг зохицуулалт хийгдэх хугацаанд ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардагдах, эдийн засгийн үндэслэлтэй, бодит зардлын хэмжээнд тулгуурлан тодорхойлно.

5.2 Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ ($BO_{\text{ш}}$) нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт зардал /НЗ/ ба хөрөнгө оруулалтын өгөөж ($ХО_ө$)-ийн нийлбэрээр тодорхойлогдоно.

$$BO_{\text{ш}} = НЗ + ХО_ө \quad (\text{мян.төг}) \quad (4)$$

5.3 Нийт зардал (НЗ) нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг (БӨӨ), богино хугацаат зээлийн хүүгийн зардал ($З_{\text{хүү}}$)-ын нийлбэрээр тодорхойлогдоно.

$$НЗ = БӨӨ + З_{\text{хүү}} \quad (\text{мян.төг}) \quad (5)$$

5.4 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг (БӨӨ)-ийг байгууллагын дүнгээр болон тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр Хүснэгт 11 - ийн дагуу тодорхойлох ба дараах зардлууд багтана. Үүнд:

- Үйлдвэрлэлийн зардал;
- Урсгал болон их засварын зардлууд;
- Удирдлагын зардал;
- Борлуулалт, маркетингийн зардал;
- Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл;
- Түрээс, лизингийн төлбөр, даатгал болон үйл ажиллагаа, хөрөнгийн холбогдох бусад төлбөр, хураамжийн зардлууд;
- Татвар, төлбөр хураамжтай холбоотой зардлууд;
- Нормативт ашиг.

5.5 Зардлыг тооцохдоо дараах мэдээ баримт, мэдээлэлд үндэслэнэ. Үүнд:

- Сүүлийн 3 жилийн НББ-ийн болон холбогдох статистик мэдээ тайлан, аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт;
- Сүүлийн жилүүдийн тайлан, эдийн засгийн бодит тооцоонд үндэслэсэн түүхий эд, бараа бүтээгдэхүүний хэмжээ;
- Тухайн хугацааны албан ёсоор батлагдсан үнэ тариф, зах зээлийн үнэ ханш;
- Албан ёсоор гэрээнд тусгасан үнэ тариф, ажил үйлчилгээний хэмжээ;
- Бусад байгууллагаас бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авсан зардал;
- Дараа оны төлөвлөгөө, зардлын өөрчлөлтийн тайлбар, холбогдох тушаал шийдвэр зэрэг болно.

5.6 Тарифын зохицуулалтад үнийн индекс, цахилгаан эрчим хүч, түлш шатахууны үнийн өсөлт, цалингийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн цаашдын чиг хандлагыг харгалзан үзнэ.

5.7 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн үндсэн хөрөнгө болон, биет бус хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд тусгахдаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, холбогдох журам зааврыг баримтлана. Элэгдлийн зардлыг тарифт салбарын бодлого чиглэл, байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Зохицуулах зөвлөлөөс баталсан аргачлал, журмыг баримтлан тодорхой хэмжээгээр тусгана. Зохицуулах зөвлөлөөс хуримтлагдсан элэгдлийн зарцуулалт, тарифт тусгасан элэгдлийн зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллах бөгөөд тухайн жилийн хөрөнгө оруулалтад төлөвлөсний дагуу зарцуулаагүй бол дараа жилийн зохицуулалт хийхдээ хасч тооцно.

5.8 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны зардалд баримтаар баталгаажаагүй, үндэслэлгүй зардал буюу хасагдах зардал (ХЗ)-ыг Зохицуулах зөвлөл хянаж, тооцож ирүүлсэн нийт зардлаас хасч тооцно.

5.9 Хөрөнгө оруулалтын өгөөж (XO_{θ})-ийг тодорхойлохдоо өгөөж тооцох хөрөнгө оруулалт ($X_{\theta T}$)-ын дүнг хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь ($XO_{\theta X}$)-иар үржүүлнэ.

$$XO_{\theta} = XO_{\theta T} \cdot XO_{\theta X} \text{ (мян.төг)} \quad (6)$$

5.10 Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь ($XO_{\theta X}$)-ийг хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд өгөөжийн хувийн жигнэсэн дундажаар тодорхойлогдоно.

$$XO_{\theta X} = \frac{3_{yx} \cdot X_{yx3} + \theta_3 \cdot \theta_{3\theta X}}{3_{yx} + \theta_3} \text{ (мян.төг)} \quad (7)$$

Үүнд: 3_{yx} - урт хугацаат зээл. мян.төг;

$Z_{ухх}$ – урт хугацаат зээлийн хүүгийн хувь;

Θ_3 - эзэмшигчийн өмч, мян.төг;

$\Theta_{зөх}$ – эзэмшигчийн өмчийн өгөөжийн хувь.

- 5.11 Өгөөж тооцох хөрөнгө оруулалтын дүн ($X_{ӨТ}$)-г өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн ($X_{ӨТ}$) болон өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн ($ЭХ_{ӨТ}$)-гийн нийлбэрээр тооцно.

$$X_{ӨТ} = X_{ӨТ} + ЭХ_{ӨТ} \text{ (мян.төг)} \quad (8)$$

- 5.12 Өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн ($X_{ӨТ}$)-г тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбогдох үндсэн хөрөнгийн анхны өртөг ($X_{аө}$)-өөс хуримтлагдсан элэгдэл / $Э_x$ /-ийг хасаж тодорхойлно.

$$Y_{ХӨТ} = X_{аө} - Э_x \text{ (мян.төг)} \quad (9)$$

- 5.13 Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн ($ЭХ_{ӨТ}$)-г тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаатай холбогдох эргэлтийн хөрөнгө ($ЭХ$)-өөс богино хугацааны өр төлбөр / $ӨТ_{бх}$ /-ийг хасаж тодорхойлно.

$$ЭХ_{ӨТ} = ЭХ - өТ_{бх} \text{ (мян.төг)} \quad (10)$$

Зургаа. Суурь үнэ тооцох

- 6.1 Суурь үнэ буюу тогтмол тариф нь төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээг байнгын бэлэн байдалд байлгах нөхцөлийн хангахад зорилготой.

- 6.2 Суурь үнийг цэвэр болон бохир усны үйлчилгээ тус бүрд тооцно.

- 6.3 Ус хэрэглээний зориулалтаас нь хамаарч суурь үнийн ялгавартай тарифыг хэрэглэнэ. Үүнд:

- Орон сууцны оршин суугчид (унд, ахуйн зориулалтаар)
- Аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид.

- 6.4 Суурь үнэ тогтоохдоо тогтмол зардлын дүнд үндэслэн үйлчилгээний төрөл тус бүрээр тооцно. Үүнд:

а/ тогтмол зардлыг хэрэглэгчдийн тоонд харьцуулах арга

$$C_v = Z_T / (12 * X) \text{ (төг/сар)} \quad (11)$$

Үүнд: C_v – суурь үнэ, төг/сар;

12- сарын тоо;

Z_T – тогтмол зардал, мян.төг;

X – хэрэглэгчийн тоо.

б/ тогтмол зардлыг биет үзүүлэлтийн хэмжээнд харьцуулах арга

$$C_{v1} = Z_T / Y_{бх} \text{ (төг/м}^3\text{)} \quad (12)$$

Үүнд: $Y_{бх}$ – үйлчилгээний биет хэмжээ, мян.м³.

- 6.5 Тогтмол зардлыг хэрэглэгчдийн тоонд харьцуулах аргыг орон сууцны хэрэглэгчдийн суурь үнийг тодорхойлоход хэрэглэнэ.

- 6.6 Тогтмол зардлыг биет үзүүлэлтийн хэмжээнд харьцуулах аргыг бусад хэрэглэгчдийн суурь үнийг тодорхойлоход хэрэглэнэ.

6.7 Хэмжээнээс хамаарсан суурь үнийг тухайн байгууллага, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийн цэвэр усны оруулга шугамын голчтой нь уялдуулан, ус зарцуулалтад үндэслэн тогтооно.

Долоо. Хэрэглэгчийн ангилал, зардлын хуваарилалт

7.1 Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг байгууллагын нэгдсэн дүнгээр тодорхойлох бөгөөд зардлыг тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр болон хэрэглэгчийн ангиллаар хуваарилна.

7.2 Цэвэр усны тариф тооцохдоо хэрэглэгчдийг усны нөөцийн зүй зохистой ашиглалтыг дэмжих зорилгоор дараах байдлаар ангилна. Үүнд:

7.2.1 Айл өрх (тоолууртай, тоолуургүй);

7.2.2 Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага;

а/ Дор дурдсанаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага;

б/ Төсөвт байгууллагууд;

в/ Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга;

г/ Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр;

7.3 Бохир усны тариф тооцохдоо усны бохирдлыг бууруулах зорилгоор хэрэглэгчдийг дараах байдлаар ангилна. Үүнд:

7.3.1 Айл өрх /тоолууртай, тоолуургүй/;

7.3.2 Үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага:

а/ Дор дурдсанаас бусад Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага;

б/ Төсөвт байгууллагууд;

в/ Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр;

г/ Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга;

7.4 Зардлыг шат дамжлага бүрээр тодорхойлох боломжгүй тохиолдолд болон хуваарилагдахгүй зардлыг цэвэр, бохир усны үйлчилгээний зардалд орлоготой нь хувь тэнцүүлж тооцно.

7.5 Тариф тооцох борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ ($BO_{шт}$)-г дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

$$BO_{шт} = BO_{ш} - O_{сх} + A_{зу} \text{ (мян.төг)} \quad (13)$$

$O_{сх}$ – Суурь хураамжийн орлого, мян.төг;

$A_{зу}$ – Гэр хорооллын хүн амын зөөврийн усны алдагдал, мян.төг;

Найм. Усны хэрэглээнээс хамаарах тариф тооцох

8.1 ТЗЭ-ийн тарифыг тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа тус бүрээр болон хэрэглэгчийн ангиллаар тогтооно.

8.2 ТЗЭ-ийн тариф (Т)-ыг тариф тооцох борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ ($BO_{шт}$)-г үйлчилгээний биет хэмжээ ($Y_{б.х}$)-д харьцуулж тодорхойлно.

$$T = \frac{BO_{шт}}{Y_{б.х}} \text{ (төг/м}^3\text{)} \quad (14)$$

8.3 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд бусад нийт үйл ажиллагаанаас хувиарлагдахгүй байгаа зардлыг борлуулалтын орлогод тухайн үйл ажиллагааны орлогын эзлэх хувь хэмжээгээр нийт зардлаас хувиалан тооцно.

Ес. Усны үйлчилгээний үнэ, тарифыг индексжүүлэх

9.1 Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд шууд нөлөөлөх зардлын бодит өөрчлөлтөөс хамааран дараах зардлыг индексжүүлж тооцно.

– Цахилгаан, дулаан, усны үйлчилгээний үнэ, тарифын өөрчлөлтөөр ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд ногдох дулаан, цахилгаан, усны зардлыг тооцоход,

– Гадаад валютын ханшны өөрчлөлтөөр шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлыг тооцоход,

– Үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийг түүхий эд, хангамжийн материал, тээвэр, материалын зардлыг тооцоход,

– Татвар, хууль, шийдвэрийн өөрчлөлтийн нөлөөллийг ус, дулаан, цахилгаан болон ашиглалтын зардал, орлогын албан татвараас бусад татвар, элэгдэл, хөрөнгө оруулалтын өгөөжийн зардлыг тооцоход,

9.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын үйл ажиллагаанаас үл хамааран ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны зардалд шууд нөлөө үзүүлэх зардал өөрчлөгдөхөд тарифыг индексжүүлнэ.

9.3 Усны үйлчилгээний тарифыг индексжүүлэхдээ дараах мэдээллийг үндэслэл болгоно. Үүнд:

– Дулаан, цахилгааны үнийн өөрчлөлтийг тооцоход Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан үнэ, тарифийн тогтоолыг үндэслэнэ,

– Усны үнийн өөрчлөлтийг тооцоход Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл (цаашид Зохицуулах зөвлөл гэх)-өөс хянасан үнэ,

– Үйлдвэрлэгчийн үнийн индекс, валютын ханшны өөрчлөлтийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан сарын болон жилийн мэдээлэлд үндэслэнэ,

– Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас хамаарч зардалд нөлөөлөх хүчин зүйлсийг “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ, тарифыг тооцох аргачлал”-ын хүрээнд тооцно.

9.4 Усны үйлчилгээний тарифыг дараах байдлаар индексжүүлнэ. Үүнд:

$$T_i = I * T_{i-1} \quad (15)$$

$$I = \frac{BOш_i}{BOш_{i-1}} \quad (16)$$

Үүнд: T_i - i хугацааны индексжүүлсэн тариф, төг/м³;

T_{i-1} - $i-1$ онд батлагдсан усны үйлчилгээний тариф, төг/м³;

I - i хугацаанд $i-1$ онд батлагдсан усны үйлчилгээний тарифыг индексжүүлэх индекс;

$BOш_i$ - i хугацаанд Зохицуулах зөвлөлөөс хянасан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (14-р томъёогоор тодорхойлно.), мян.төг;

$BOш_{i-1}$ - $i-1$ онд Зохицуулах зөвлөлөөс баталсан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ, мян.төг.

9.5 Цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шаардлагатай тохиолдолд жилд 1 удаа индексжүүлж, Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын цэвэр ус худалдан авах, хэрэглээнээс гарсан бохир ус нийлүүлэх бөөний тарифт зохицуулалт хийнэ.

Арав. Хэрэглэгчийн төлбөр тооцох

- 10.1 ТЗЭ-д Зохицуулах зөвлөлөөс батлагдсан тарифын дагуу хэрэглэгчийн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг сар бүр тооцож нэхэмжилнэ.
- 10.2 Хэрэглэгчийн төлөх цэвэр, бохир усны үйлчилгээний нийт төлбөрийг тооцохдоо тарифыг тухайн сард хэрэглэсэн усны хэмжээгээр үржүүлж, суурь үнэ нэмнэ. Үүнд:

$$T\theta_c = T\theta_{\text{ц}} + T\theta_{\text{б}} + C_{\text{с}} \quad (17)$$

$T\theta_c$ - хэрэглэгчийн цэвэр, бохир усны үйлчилгээний тухайн сарын нийт төлбөр, төг;

$T\theta_{\text{ц}}$ - цэвэр усны үйлчилгээний тухайн сарын төлбөр, төг;

$T\theta_{\text{б}}$ - бохир усны үйлчилгээний тухайн сарын төлбөр, төг;

$C_{\text{с}}$ - суурь үнэ, төг.

- 10.3 Хэрэглэгчийн цэвэр, бохир усны үйлчилгээний тухайн сарын төлбөр нь тарифыг тухайн сард хэрэглэсэн усны хэмжээгээр үржүүлж тодорхойлогдоно. Үүнд:

$$T\theta_{\text{ц}} = T_{\text{ц}} * X_{\text{ус}} \quad (18)$$

$$T\theta_{\text{б}} = T_{\text{б}} * X_{\text{ус}} \quad (19)$$

$T_{\text{ц}}$ - батлагдсан цэвэр усны тариф, төг/м³;

$T_{\text{б}}$ - батлагдсан бохир усны тариф, төг/м³;

$X_{\text{ус}}$ – хэрэглэгчийн сард хэрэглэсэн усны хэмжээ, м³;

- 10.4 Хэрэглэгчийн сард хэрэглэсэн цэвэр усны хэмжээг тухайн сард хэрэглэсэн, халуун, хүйтэн усны нийлбэрээр тодорхойлох бөгөөд тоолуургүй тохиолдолд холбогдох байгууллагаас тогтоосон ус хэрэглээний нормоор тооцно.
- 10.5 Хэрэглэгчийн сард хэрэглэсэн бохир усны хэмжээ нь цэвэр усны хэмжээтэй тэнцүү байна.
- 10.6 Суурь хураамжийг хүйтэн усны оруулга шугамын голч буюу тоолуур суурилуулсан шугам (тоолуур)-ын голчоор тооцно.

Арван нэг. Бусад зүйл

- 11.1 Тарифын тооцоонд тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны зардлыг баримтжуулах эрх зүйн акт, баримтуудыг хавсаргана.
- 11.2 ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БОш)-г Зохицуулах зөвлөл жил бүр хянаж батлах ба ба тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага холбогдох тооцоо судалгааг заасан хугацаанд бүрэн, үнэн, зөв ирүүлэх шаардлагатай. Судалгаанд сүүлийн 3 жилийн үйл ажиллагаа хамрагдана.
- 11.3. Тарифын саналыг хянах хянах явцад баримтаар баталгаажуулаагүй, Зохицуулах зөвлөл үндэслэлгүй гэж үзсэн зардлыг тариф тооцох зардлаас хасч борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг хянаж, батална.
- 11.4. Тарифын саналыг онлайнгаар ирүүлэхийн зэрэгцээ албан бичгээр баталгаажуулж ирүүлнэ.

11.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тарифын санал ирүүлэхдээ хяналт хийхэд шаардлагатай дараах материалыг хавсаргаж хуудас бүрийг дугаарлан, хавтаслаж Зөвлөлд ирүүлнэ.

- 11.5.1. Тариф өөрчлүүлэх хүсэлт албан бичиг
- 11.5.2. Байгууллагын гэрчилгээний хуулбар
- 11.5.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- 11.5.4. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга
- 11.5.5. Байгууллагын бизнес төлөвлөгөө
- 11.5.6. Өнгөрсөн оны бизнес төлөвлөгөө, түүний биелэлт
- 11.5.7. Санхүү, эдийн засгийн судалгааны Хүснэгтүүд (Хавсралтад заасан)
- 11.5.8. Тусгай зөвшөөрлийн хүрээний үйл ажиллагааны зардлыг баримтжуулах эрх зүйн акт, баримтууд
- 11.5.9. Зөвлөлөөс нэмэлт болгон шаардсан холбогдох бусад баримт бичгүүд зэргийг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлан Зохицуулах зөвлөлд албан ёсоор ирүүлнэ.

--- о О о ---

БҮРТГЭЛ

Хүснэгт 1

№	Бүртгэлийн үзүүлэлт	Тусгай зөвшөөрөл хүсэгч
1	Оноосон нэр	
2	Өмчийн хэлбэр	
3	Улсын бүртгэлийн дугаар	
4	Регистер дугаар	
5	Байгуулагдсан огноо	
6	Байгууллагын албан хаяг	
7	Удирдлагын нэр	
8	И-мэйл хаяг	-
9	Холбоо барих утас	
10	Тусгай зөвшөөрлийн хүрээний үйл ажиллагааны чиглэл	
11	Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан хугацаа	
12	Бусад үйл ажиллагааны чиглэл	
13	Ерөнхий инженер - нэр, утас, и-мэйл хаяг	
14	Ерөнхий нягтлан - нэр, утас, и-мэйл хаяг	
15	Ус хангамжийн инженер - нэр, утас, и-мэйл хаяг	
16	Эдийн засагч - нэр, утас, и-мэйл хаяг	
17	Тооцооны нягтлан - нэр, утас, и-мэйл хаяг	

А.Цэвэр усны үйлчилгээний тариф (НӨАТ-гүй)

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Худалдан авах бөөний тариф	Одоо мөрдөгдөж байгаа тариф	Өөрийн өртөг 1 м ³	Санал болгож байгаа тариф	Өсөлт хувиар %
1	2	3	4	5	6	7	8
Төвлөрсөн ус хангамж							
1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ	төг/м ³				
		Үүнд: Төсөвт байгууллагууд	төг/м ³				
		Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	төг/м ³				
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	төг/м ³				
2	Айл өрх	тоолууртай	төг/м ³				
		тоолуургүй	төг/м ³				
3	Ус түгээх байр /холбогдсон/	төг/м ³					
4	Ус түгээх байр /зөөврөөр/	төг/м ³					
5	Зөөврөөр ҮААНБ-д	төг/м ³					

Б.Бохир усны үйлчилгээний тариф (НӨАТ-гүй)

1	2	3	4	5	6	7	8
1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ	төг/м ³				
		Үүнд: Төсөвт байгууллагууд	төг/м ³				
		Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр	төг/м ³				
		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга	төг/м ³				
2	Айл өрх	тоолууртай	төг/м ³				
		тоолуургүй	төг/м ³				
3	Зөөврөөр бохир ус татан зайлуулах	төг/м ³					

/тамга/ ".....".....ийн

Захирал / /
 Ерөнхий нягтлан бодогч / /
 Эдийн засагч / /

УСНЫ БАЛАНС

Хүснэгт 3

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж он он	... он	... он төлөвлөгөө
1	Цэвэр усны баланс					
1.1	Олборлосон ус	мян.м ³				
1.2	Худалдан авсан ус	мян.м ³				
1.3	Борлуулсан ус	мян.м ³				
1.4	Галын ус	мян.м ³				
1.5	Шугам дүүргэлтийн ус	мян.м ³				
1.6	Орлого болоогүй ус	мян.м ³				
1.6.1	Өөрийн хэрэглээ	мян.м ³				
1.6.2	Бичилт хийгдээгүй ус	мян.м ³				
1.6.3	Аваар гэмтлийн ус	мян.м ³				
1.6.4	Шугамын алдагдал	мян.м ³				
2	Бохир усны баланс					
2.1	Татан зайлуулсан бохир ус /бичилт хийсэн/	мян.м ³				
2.2	Цэвэрлэсэн бохир ус	мян.м ³				
2.3	Орлого болоогүй бохир ус	мян.м ³				

/тамга/ "....."ийн

Захирал /	/
Ерөнхий инженер /	/
Эдийн засагч /	/

"....."-ИЙН НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮ -
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж он гүйцэтгэл он гүйцэтгэл он гүйцэтгэл он төлөвлөгөө
1	Байгууллагын нийт үзүүлэлт					
1.1	Нийт орлого	мян.төг				
1.2	Нийт зардал	мян.төг				
1.3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	мян.төг				
1.4	ААНОАТ	мян.төг				
1.5	Татварын дараах ашиг, алдагдал	мян.төг				
2	УХАТ-ын тусгай зөвшөөрлийн хүрээнд					
2.1	Орлого	мян.төг				
2.2	Үүнээс: Цэвэр, бохир усны үйлчилгээний	мян.төг				
2.3	Бусад	мян.төг				
2.4	Зардал	мян.төг				
2.5	Ашиг/алдагдал	мян.төг				
3	Дулаан хангамж					
3.1	Орлого	мян.төг				
3.2	Зардал	мян.төг				
3.3	Ашиг алдагдал	мян.төг				
4	Цахилгаан					
4.1	Орлого	мян.төг				
4.2	Зардал	мян.төг				
4.3	Ашиг алдагдал	мян.төг				
5	Бусад үйл ажиллагаа					
5.1	Орлого	мян.төг				
5.2	Зардал	мян.төг				
5.3	Ашиг алдагдал	мян.төг				
6	Балансын зарим үзүүлэлт					
6.1	Нийт үндсэн хөрөнгө	мян.төг				
6.1.1	Үүнээс:УХАТ-ын ТЗ-ийн үйл ажиллагаанд ногдох	мян.төг				
6.2	Эргэлтийн хөрөнгө	мян.төг				
6.2.1	Үүнээс: Мөнгөн хөрөнгө	мян.төг				
6.2.2	Нийт авлага	мян.төг				
6.2.3	Нийт өглөг	мян.төг				
6.2.4	Үүнээс: Урт хугацаат зээл	мян.төг				
7	Ажиллагсад					
7.1	Нийт ажиллагсад	тоо				
7.2	Цалингийн сан	мян.төг				
7.3	Дундаж цалин	төг/сар				
8	Байгууллагын орлогын 1 төгрөгт ногдох зардал					
9	Санхүүгийн харьцаа					
9.1	Эргэлтийн харьцаа	1 ≤				
9.2	Төлбөр гүйцэтгэх чадвар	2 ≤				
9.3	Ашгийн норм	0 ≤				

/тамга/ "....."-ийн

Захирал / /
 Ерөнхий нягтлан бодогч / /
 Эдийн засагч / /

"....."-ИЙН ОНЫ ЗАРДАЛ, ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ (мян. төгрөгөөр)

Хүснэгт 5

№	Зардлын төрөл	Байгууллагын нийт дүн			Цэвэр, бохир ус			Дулаан			Цахилгаан			Бусад		
		Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү
ЗАРДАЛ																
1	Үндсэн ба нэмэгдэл цалин, шагнал															
2	Байгууллагаас төлөх ЭМД, НДШ															
3	Засвар үйлчилгээ															
4	Материал, хангамжийн зардал															
5	Ус цэвэрлэгээ, ариутгалын бодис болон бусад холбогдох зардал															
6	Түлш, шатахууны зардал															
7	Ашиглалт-Цахилгаан өөрийн хэрэглээ															
8	-Дулаан															
9	-Ус - өөрийн хэрэглээ															
10	Албан томилолтын зардал															
11	Бичиг хэрэг, албан хэрэгцээний зардал															
12	Харилцаа холбооны зардал															
13	Хөдөлмөр хамгааллын зардал															
14	Гүйцэтгэх удирдлагын зардал															
15	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал															
16	Борлуулалт, маркетингийн зардал															
17	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал															
18	Гадны үйлчилгээний хөлс															
19	Даатгалын зардал															

№	Зардлын төрөл	Байгууллагын нийт дүн			Цэвэр, бохир ус			Дулаан			Цахилгаан			Бусад		
		Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү
20	Зохицуулалт үйлчилгээний хөлс															
21	Үйл ажиллагааны бусад зардал															
22	Ажиллагсдын нийгмийн зардал															
23	Зээлийн хүүгийн зардал															
24	Худалдан авалт: Цахилгаан															
25	Дулаан															
26	Цэвэр ус															
27	Бохир ус															
28	Бусад зардал															
29	Байгаль орчин хамгаалах зардал															
30	ААНОАТ-аас бусад татвар, хураамж															
31	Нийт зардал															
ОРЛОГО																
32	Борлуулалтын орлого															
33	Бусад орлого															
34	Нийт орлого															
35	Ашиг/алдагдал															
36	Урт хугацаат зээлийн үндсэн төлбөр															

/тамга/

"....."-ийн

Захирал

Ерөнхий нягтлан бодогч

Эдийн засагч

"....."-ИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД
АШИГ/АЛДАГДАЛ

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж он Гүйцэтгэл он Гүйцэтгэл он Гүйцэтгэл он Төлөвлөгөө	Өсөлт/ бууралт
1	Цэвэр, бохир усны үйлчилгээний нийт зардал	мян.төг					
1.1	Үүнээс: Төвлөрсөн ус хангамжийн зардал	мян.төг					
1.2	Ариутгах татуургын зардал	мян.төг					
1.3	УТБ, зөөврийн ус хангамж	мян.төг					
1.4	Бусад	мян.төг					
2	Цэвэр, бохир усны үйлчилгээний нийт орлого	мян.төг					
2.1	Цэвэр усны үйлчилгээний орлого	мян.төг					
2.1.1	Үүнээс: ҮААНБ	мян.төг					
2.1.2	Айл өрхийн	мян.төг					
2.1.3	УТБ, зөөврийн ус хангамж	мян.төг					
2.1.4	Өөрийн хэрэглээ /дулаан/	мян.төг					
2.1	Бохир усны үйлчилгээний орлого	мян.төг					
2.1.1	Үүнээс: ҮААНБ	мян.төг					
2.1.2	Айл өрхийн	мян.төг					
2.1.3	Зөөврийн	мян.төг					
2.3	Суурь хураамжийн орлого	мян.төг					
2.4	Бусад орлого	мян.төг					
3	Цэвэр бохир усны үйлчилгээний ашиг алдагдал	мян.төг					

/тамга/

"....."-ийн

Захирал / /

Ерөнхий нягтлан бодогч / /

Эдийн засагч / /

"....."-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН СУДАЛГАА

Хүснэгт 7

Хэрэглэгчийн ангилал	 он гүйцэтгэл	 он гүйцэтгэл	 он гүйцэтгэл	 он төлөвлөгөө		Өмнөх оны гүйцэтгэлээс өссөн/буурсан	
		Усны хэмжээ /мян.м ³ /	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м ³ /	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м ³ /	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м ³ /	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м ³ /	Орлого /мян.төг/
1	Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт орлого										
1.1	Цэвэр усны орлогын дүн										
1.1.1	YAАНБ	Дор дурдсанаас бусад YAАНБ									
1.1.2		Үүнд: Төсөвт байгууллагууд									
1.1.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга									
1.1.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр									
1.1.5		Зөөврөөр									
1.1.6	Айл өрх	тоолууртай									
1.1.7		тоолуургүй									
1.1.8		УТБ									
1.1.9		Зөөврөөр									
1.1.10	Өөрийн хэрэглээ /дулаан/										
1.2	Бохир усны орлогын дүн										
1.2.1	YAАНБ	Дор дурдсанаас бусад YAАНБ									
1.2.2		Үүнд: Төсөвт байгууллагууд									
1.2.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр									

Хэрэглэгчийн ангилал		 он гүйцэтгэл	 он гүйцэтгэл	 он гүйцэтгэл	 он төлөвлөгөө		Өмнөх оны гүйцэтгэлээс өссөн/буурсан	
			Усны хэмжээ /мян.м³/	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м³/	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м³/	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м³/	Орлого /мян.төг/	Усны хэмжээ /мян.м³/	Орлого /мян.төг/
1.2.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга										
1.2.5		Зөврөөр										
1.2.6	Айл өрх	тоолууртай										
1.2.7		тоолуургүй										
1.2.8		Зөврөөр										
1.3	Суурь хураамжийн орлогын дүн											
1.3.1.	ҮААНБ-ын											
1.3.2.	Айл өрхийн											
1.4	Бусад орлого											
2	Борлуулалтын дундаж үнэ											
2.1	Цэвэр ус											
2.2	Бохир ус											

/тамга/ "....."ийн
 Захирал / /
 Ерөнхий инженер / /
 Эдийн засагч / /

"....."-ИЙН УСНЫ БОРЛУУЛАЛТЫН СУДАЛГАА, САРААР

Хүснэгт 8

1. Борлуулалтын бичилт биет хэмжээгээр

Хэрэглэгчийн ангилал		хэмжих нэгж	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	Жилийн дүн
1	Цэвэр усны борлуулалтын дүн		мян.м ³												
1.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ	мян.м ³												
1.2		Үүнд: Төсөвт байгууллагууд	мян.м ³												
1.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	мян.м ³												
1.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	мян.м ³												
1.5		Зөөврөөр	мян.м ³												
1.6	Айл өрх	тоолууртай	мян.м ³												
1.7		тоолуургүй	мян.м ³												
1.8		УТБ /холбогдсон/	мян.м ³												
1.9		УТБ зөөврөөр	мян.м ³												
2	Татан зайлуулсан бохир ус		мян.м ³												
2.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ	мян.м ³												
2.2		Үүнд: Төсөвт байгууллагууд	мян.м ³												
2.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр	мян.м ³												
2.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга	мян.м ³												
2.5		Зөөврөөр	мян.м ³												
2.6	Айл өрх	тоолууртай	мян.м ³												
2.7		тоолуургүй	мян.м ³												
2.8		Зөөврөөр	мян.м ³												
3	Суурь хураамж тооцсон хэрэглэгч		тоо												
3.1	ҮААНБ		тоо												
3.2	Айл өрх		тоо												

Тайлбар: Тайлант оны гүйцэтгэл дараа оны төлөвлөгөөгөөр хийнэ.

2. Борлуулалтын орлого /мян.төг/

Хэрэглэгчийн ангилал		1 -р сар	2 -р сар	3 -р сар	4 -р сар	5 -р сар	6 -р сар	7 -р сар	8 -р сар	9 -р сар	10 -р сар	11 -р сар	12 -р сар	Жилийн дүн
1	Цэвэр усны борлуулалтын дүн													
1.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ												
1.2		Үүнд: Төсөвт байгууллагууд												
1.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга												
1.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр												
1.5		Зөөврөөр												
1.6	Айл өрх	тоолууртай												
1.7		тоолуургүй												
1.8		УТБ /холбогдсон/												
1.9		УТБ зөөврөөр												
2	Татан зайлуулсан бохир ус													
2.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ												
2.2		Үүнд: Төсөвт байгууллагууд												
2.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр												
2.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга												
2.5		Зөөврөөр												
2.6	Айл өрх	тоолууртай												
2.7		тоолуургүй												
2.8		Зөөврөөр												
3	Суурь хураамжийн орлого													
3.1	ҮААНБ													
3.2	Айл өрх													

Тайлбар: Тайлант оны гүйцэтгэл дараа оны төлөвлөгөөгөөр хийнэ.

3. Тариф /төг/м³/

Хэрэглэгчийн ангилал		1 -р сар	2 -р сар	3 -р сар	4 -р сар	5 -р сар	6 -р сар	7 -р сар	8 -р сар	9 -р сар	10 -р сар	11 -р сар	12 -р сар
1	Цэвэр усны борлуулалтын дүн												
1.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ											
1.2		Үүнд: Төсөвт байгууллагууд											
1.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга											
1.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр											
1.5		Зөөврөөр											
1.6	Айл өрх	тоолууртай											
1.7		тоолуургүй											
1.8		УТБ /холбогдсон/											
1.9		УТБ зөөврөөр											
2	Татан зайлуулсан бохир ус												
2.1	ҮААНБ	Дор дурдсанаас бусад ҮААНБ											
2.2		Үүнд: Төсөвт байгууллагууд											
2.3		Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр											
2.4		Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга											
2.5		Зөөврөөр											

Тайлбар: Тайлант оны гүйцэтгэл дараа оны төлөвлөгөөгөөр хийнэ.

/тамга/ ".....".....ийн

Захирал / /

Ерөнхий нягтлан бодогч / /

Эдийн засагч / /

"....."-ИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН СУДАЛГАА

Хүснэгт 9

А. УХАТ-ын үйл ажиллагааны зардлын судалгаа, жилээр /мян.төг/

№	Зардлын төрлүүд он гүйцэтгэл он гүйцэтгэл он гүйцэтгэл он төлөвлөгөө	Төлөвлөгөөт тайлант оны зөрүү	Зардал өссөн тухай тайлбар
1	Ус худалдан авалт						
2	Үндсэн ба нэмэгдэл цалин						
3	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ						
4	Цахилгаан						
5	Ашиглалтын зардал /ус, дулаан, бусад/						
6	Түлш, шатахууны зардал						
7	Засвар үйлчилгээ						
8	Ус цэвэрлэгээ ариутгал						
9	Лаборатори, шинжилгээ						
10	Материал, хангамж						
11	Бичиг хэрэг, албан хэрэгцээний зардал						
12	Харилцаа холбоо						
13	Томилолт						
14	Сургалт						
15	Хөдөлмөр хамгаалал						
16	Маркетинг, борлуулалт						
17	Гүйцэтгэх удирдлагын зардал						
18	ТУЗ-ын зардал						
19	Элэгдлийн зардал						
20	Гадны үйлчилгээний хөлс						
21	Байгаль орчин хамгаалах зардал						
22	Татвар, даатгалын зардал						
23	Үйл ажиллагааны бусад зардал						
	Үндсэн үйл ажиллагааны зардал (БӨӨ)-н дүн						
24	Ажиллагсдын нийгмийн зардал						

№	Зардлын төрлүүд он гүйцэтгэл он гүйцэтгэл он гүйцэтгэл он төлөвлөгөө	Төлөвлөгөөт тайлант оны зэрүү	Зардал өссөн тухай тайлбар
25	Зээлийн хүүгийн зардал						
	Хөрөнгө оруулалтын өгөөжийн дүн						
	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ						
26	Бусад шагнал, урамшуулал						
27	Спорт, соёлын арга хэмжээ						
28	Бусад						
	Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн						
	УХАТ-ын үйл ажиллагааны нийт зардал						
29	Урт хугацаат зээлийн үндсэн төлбөр						

Б. УХАТ-ын үйл ажиллагааны зардлын судалгаа, сараар (Тайлант оны гүйцэтгэл дараа оны төлөвлөгөөгөөр хийнэ), /мян.төг/

№	Зардлын төрөл	1 -р сар	2 -р сар	3 -р сар	4 -р сар	5 -р сар	6 -р сар	7 -р сар	8 -р сар	9 -р сар	10 -р сар	11 -р сар	12 -р сар оны дүн
1	Ус худалдан авалт													
2	Үндсэн ба нэмэгдэл цалин													
3	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ													
4	Цахилгаан													
5	Ашиглалтын зардал /ус, дулаан, бусад/													
6	Түлш, шатахууны зардал													
7	Засвар үйлчилгээ													
8	Ус цэвэрлэгээ ариутгал													
9	Лаборатори, шинжилгээ													
10	Материал, хангамж													
11	Бичиг хэрэг, албан хэрэгцээний зардал													
12	Харилцаа холбоо													
13	Томилолт													
14	Сургалт													
15	Хөдөлмөр хамгаалал													
16	Маркетинг, борлуулалт													
17	Гүйцэтгэх удирдлагын зардал													
18	ТУЗ-ын зардал													

№	Зардлын төрөл	1 -р сар	2 -р сар	3 -р сар	4 -р сар	5 -р сар	6 -р сар	7 -р сар	8 -р сар	9 -р сар	10 -р сар	11 -р сар	12 -р сар оны дүн
19	Элэгдлийн зардал													
20	Гадны үйлчилгээний хөлс													
21	Байгаль орчин хамгаалах зардал													
22	Татвар, даатгалын зардал													
23	Үйл ажиллагааны бусад зардал													
Үндсэн үйл ажиллагааны зардал (БӨӨ)														
24	Ажиллагсдын нийгмийн зардал													
25	Зээлийн хүүгийн зардал													
Хөрөнгө оруулалтын өгөөжийн дүн														
26	Шагнал урамшуулал													
27	Спорт, соёлын арга хэмжээ													
28	Бусад													
Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн														
УХАТ-ын үйл ажиллагааны нийт зардал														
29	Урт хугацаат зээлийн үндсэн төлбөр													

В. Худалдан авалтын өртгийн тооцоо, сараар, (Тайлант оны гүйцэтгэл дараа оны төлөвлөгөөгөөр хийнэ.)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	1 -р сар	2 -р сар	3 -р сар	4 -р сар	5 -р сар	6 -р сар	7 -р сар	8 -р сар	9 -р сар	10 -р сар	11 -р сар	12 -р сар оны дүн
1	Худалдан авсан цэвэр ус	мян.м ³													
2	Нийлүүлсэн бохир ус	мян.м ³													
3	Бөөний Цэвэр ус	төг/м ³													
4	тариф Бохир ус	төг/м ³													
5	Худалдан авсан цэвэр усны зардал	мян.төг													
6	Нийлүүлсэн бохир усны зардал	мян.төг													
7	Суурь хураамжийн зардал	мян.төг													
Худалдан авалтын нийт зардал		мян.төг													

Тайлбар: Хангагчид төлж байгаа суурь хураамж тооцдог шугамын голчийн талаар мэдээллийг нэмж тусгана.

/тамга/ ".....".....ийн

Захирал / /

Ерөнхий нягтлан бодогч / /

Эдийн засагч / /

"....." -ИЙН АЖИЛЛАГСДЫН ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛАЛ,
НИЙГМИЙН ЗАРДЛЫН СУДАЛГАА

Хүснэгт 10

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж он гүйцэтгэл он төлөвлөгөө	Өөрчлөлт
1	Нийт ажиллагсад	тоо			
1.1	Үүнээс: УХАТ	тоо			
2	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг			
2.1	Үүнээс: Үндсэн	мян.төг			
2.2	Нэмэгдэл	мян.төг			
3	Шагнал, урамшуулал, хөнгөлөлт, чөлөөлөлт	мян.төг			
3.1	Үүнээс: Сарын үр дүн	мян.төг			
3.2	Жилийн үр дүнгийн шагнал	мян.төг			
3.3	Хөнгөлөлтүүд	мян.төг			
3.4	Бусад шагнал урамшуулал	мян.төг			
	Нийт цалин, хөнгөлөлт, урамшуулал	мян.төг			
3.5	Нэмэгдэл цалингийн эзлэх хувь	%			
3.6	Сарын шагналт цалингийн хувь	%			
3.7	Сарын дундаж цалин	сар			
	Ажиллагсдын дундаж цалин /сарын/	төг/сар			
а	Удирдлагын нийт цалин	мян.төг			
	Үүнээс: Сарын үр дүн	мян.төг			
	Жилийн үр дүнгийн шагнал	мян.төг			
	Хөнгөлөлтүүд	мян.төг			
	Бусад шагнал урамшуулал	мян.төг			
	Удирдлагын сарын дундаж цалин	төг/сар			
б	ИТА, Албан хаагчид	мян.төг			
	ИТА, албан хаагчдын нийт цалин	мян.төг			
	Үүнээс: Сарын үр дүн	мян.төг			
	Жилийн үр дүнгийн шагнал	мян.төг			
	Хөнгөлөлтүүд	мян.төг			
	Бусад шагнал урамшуулал	мян.төг			
	Дундаж цалин /сарын/	төг/сар			
в	Ажилчид	тоо			
	Ажилчдын нийт цалин	мян.төг			
	Үүнээс: Сарын үр дүн	мян.төг			
	Жилийн үр дүнгийн шагнал	мян.төг			
	Хөнгөлөлтүүд	мян.төг			
	Бусад шагнал урамшуулал	мян.төг			
	Дундаж цалин /сарын/	төг/сар			
5	Ажиллагсдын нийгмийн зардал	мян.төг			

/тамга/ ".....".....ИЙН

Ерөнхий нягтлан бодогч / /
Эдийн засагч / /

"....."-ИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ
ӨӨРИЙН ӨРТГИЙН ТООЦОО, ОН

Хүснэгт 11

№	Зардлын төрөл	Нийт	Төвлөрсөн		Зөвөр, УТБ	Шат дамжлагаар			
			Цэвэр ус	Бохир ус		Эх үүсвэр	ЦБ	Бохир ӨН	Бусад
1	Үндсэн материалын зардал								
1.1	Ус худалдан авалт								
1.2	Бохир ус нийлүүлэлт								
2	Цалингийн сан								
2.1	Үүнд: Үндсэн, нэмэгдэл цалин								
2.2	Шагнал, урамшуулал								
2.3	Хөнгөлөлт урамшуулал								
2.4	ЭМД, НДШ								
3	Ашиглалтын зардал								
3.1	Үүнд: Цахилгаан								
3.2	Дулаан								
3.3	Ус								
3.4	Түлээ, нүүрс								
3.5	Түлш, шатахуун								
3.6	Харуул хамгаалалт								
3.7	Тээвэр								
3.8	Бусад								
4	Засвар үйлчилгээ								
4.1	Үүнд: Барилга байгууламж								
4.2	Тоног, төхөөрөмж								
4.3	Бусад								
5	Ус цэвэрлэгээ, ариутгал								
5.1	Үүнд: Хлорын зардал								
5.2	Бусад химийн бодис								
5.3	Лагийн зардал								
5.4	Бусад								
6	Материал, хангамжийн								
6.1	Үүнд: Багаж, хэрэгсэл								
6.2	Цэвэрлэгээний материал								
6.3	Шатах, тослох материал								
6.4	Сэлбэг хэрэгсэл								
6.5	Аваарын нөөц								
6.6	Бусад								
7	Албан хэрэгцээний зардал								
7.1	Үүнд: Бичиг хэргийн зардал								
7.2	Шуудан, холбоо								
7.3	Томилолт								
7.4	Сургалтын зардал								
7.5	Бусад								
8	Лаборатори, шинжилгээ								
8.1	Үүнд: Реактив, бодис								
8.2	Шил сав, хэрэгсэл								
8.3	Шинжилгээ								
8.4	Хөндлөнгийн хяналт								
8.5	Бусад								
9	Хөдөлмөр хамгаалал								
9.1	Аюулгүй ажиллагаа								
9.2	Эрүүл ахуйн								
9.3	Бусад								
10	Маркетинг, борлуулалт								
10.1	Үүнд: Усны бичилт								
10.2	Зар сурталчилгаа								
10.3	Шалгалт, баталгаажуулалт								
10.4	Бусад								

№	Зардлын төрөл	Нийт	Төвлөрсөн		Зөөвөр, УТБ	Шат дамжлагаар			
			Цэвэр ус	Бохир ус		Эх үүсвэр	ЦБ	Бохир ӨН	Бусад
11	Гүйцэтгэх удирдлагын								
11.1	Үүнд: Цалин, НДШ								
11.2	Албан томилолт								
11.3	Шатахуун								
11.4	Бичиг хэрэг								
11.5	Шуудан, холбоо								
11.6	Бусад								
12	ТУЗ-ын зардал								
12.1	Үүнд: ТУЗ-ын цалин, НДШ								
12.2	Бусад								
13	Элэгдэл								
13.1	Үүнд: Үл хөдлөх хөрөнгө								
13.2	Техник, тоног төхөөрөмж								
13.3	Тавилга, эд хогшил								
13.4	Биет бус хөрөнгө								
14	Гадны үйлчилгээ								
14.1	Үүнд: Түрээс								
14.2	З/ү-ний хөлс								
14.3	Хөндлөнгийн хяналт								
14.4	Программ хангамж								
14.5	Банкны үйлчилгээ								
14.6	Бусад								
15	Байгаль орчин хамгаалах								
15.1	Үүнд: Нөхөн сэргээлт								
15.2	Зүлэгжүүлэлт, мод тарих								
15.3	Бусад								
16	Даатгалын зардал								
16.1	Үүнд: Тээврийн хэрэгслийн								
16.2	Үл хөдлөх хөрөнгийн								
16.3	Бусад								
17	ААНОАТ-аас бусад татвар								
17.1	Үүнд: Газрын төлбөр								
17.2	Үл хөдлөх хөрөнгийн								
17.3	Тээврийн хэрэгслийн								
17.4	Бусад								
Бүрэн өөрийн өртөг /БӨӨ/									
18	Ажиллагсдын нийгмийн зардал								
18.1	Түлээний хөнгөлөлт								
18.2	Тэтгэмж тусламж								
18.3	Бусад								
19	Хөрөнгө оруулалтын зардал								
19.1	Богино хугацаат зээлийн хүү								
19.2	Урт хугацаат зээлийн хүү								
НИЙТ ЗАРДАЛ									
Борлуулсан ус, мян.м³									
1 м³ усны өртөг, төг/м³									

Тайлбар: ЦБ –Цэвэрлэх байгууламж, ӨН – өргөх насос, З/ү – зохицуулалт, үйлчилгээ

/тамга/ "....."-ийн

Захирал / /
Ерөнхий нягтлан бодогч / /
Эдийн засагч / /

А.Хэрэглэгчийн тоо, төрлөөр

№	Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж он гүйцэт гэл он гүйцэт гэл он гүйцэт гэл он төлөв лөгөө
1	Ус хангамж						
1.1	YAАНБ	Төвлөрсөн шугамд холбогдсон	Дор дурдсанаас бусад YAАНБ	тоо			
1.2			Үүнд: Төсөвт байгууллагууд	тоо			
1.3			Спирт, архи, пиво, ундаа, жүүс усны үйлдвэр, автомашин угаалга	тоо			
1.4			Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр	тоо			
1.5	Зөөврөөр		тоо				
1.6	Бүгд		тоо				
1.7	Айл өрх	Т/ш-д холбогдсон	Тоолууртай	өрх			
1.8			Тоолуургүй	өрх			
1.9			УТБ	өрх			
1.10		УТБ, зөөврөөр		өрх			
1.11		Бүгд		өрх			
Нийт хэрэглэгч			тоо				
2	Ариутгах татуурга						
2.1	YAАНБ	Төвлөрсөн шугамд холбогдсон	Дор дурдсанаас бусад YAАНБ	тоо			
2.2			Үүнд: Төсөвт байгууллагууд	тоо			
2.3			Спирт, архи, пиво, ундаа, жүүс, усны үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр	тоо			
2.4			Ноос, ноолуур, арьс шир, өлөн гэдэс боловсруулах үйлдвэр, автомашин угаалга	тоо			
2.5	Зөөврөөр		тоо				
2.6	Бүгд		тоо				
2.7	Айл өрх	Т/ш-д холбогдсон	Тоолууртай	өрх			
2.8			Тоолуургүй	өрх			
2.9		Зөөврөөр		өрх			
2.10		Бүгд		өрх			
Нийт хэрэглэгч			тоо				

Б.Суурь хураамж тооцох хэрэглэгчийн судалгаа (Цэвэр усны тоолуур суурилагдсан шугамын голчоор)

№	Үзүүлэлт	Хэрэглэгчийн тоо			
	 он гүйцэтгэл он гүйцэтгэл он гүйцэтгэл он төлөвлөгөө
1	Айл өрх				
	Цэвэр усны оролтын шугамын голч, мм	Үйлдвэрлэл, үйлчилгээ, ААНБ			
2	15				
3	20				
4	25				
5	32				
6	40				
7	50				
8	65				
9	80				
10	100				
11	125				
12	150				
13	200				
14	250				
15	300				
16	400 түүнээс дээш				
НИЙТ ДҮН					

/тамга/ ".....".....ийн

Захирал / /
 Ерөнхий нягтлан бодогч / /
 Эдийн засагч / /

--- о о о ---